

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2013 оны 3 дугаар сарын 27-ны өдөр болж Монголбанкны зөвлөлийн хурлаас 2012 онд гаргасан шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилтийн байдалтай танилцан хэлэлцэв.

Монголбанкны зөвлөл нь 2012 онд 39 удаа хуралдаж, 175 асуудал хэлэлцэж, 220 заалт бүхий шийдвэр гаргаж Монголбанкны нэгж (газар хэлтэс, алба)-д үүрэг даалгавар өгч ажилласан байна. Шийдвэрийн хэрэгжилт нь 93.2 хувьтай байна.

Монголбанкны Зөвлөлийн хурлын шийдвэрийн биелэлтийг дүгнэх үндэслэл, хэрэгжилтэд хяналт тавьж буй арга барилыг боловсронгуй болгож, хурлын дотоод зохион байгуулалт (хурлын баримт бичиг, шийдвэрийн биелэлтэд тавих хяналтыг электронжуулах гэх мэт)-ыг сайжруулж ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөмж болгов.

Мөн тус хурлаар Монголбанкны Дотоод хяналт үйл ажиллагааны эрсдлийн газрын хянан шалгагч нартай дотоод хяналтын асуудлаар, Монголбанкны 2012 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийж буй “ПрайсуотерхаусКуперс ” ХХК-ийн аудиторуудтай санал солилцсон уулзалтын үр дүнгийн талаар болон Монголбанкны 2012 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн тухай мэдээллийг тус тус сонссон байна.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ